

# **“ХАРХОРИН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 03-р сарын 28 өдөр

Дугаар 01

Хархорин сум

Компанийн 2014 оны үйл ажиллагаатай холбогдуулан  
ТҮЗ-аас гаргасан дүгнэлтийг батлах тухай

“Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн  
ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.9  
дүгээр заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

Компанийн 2014 оны бизнесийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах  
Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

П.БИШРЭЛ



# “ХАРХОРИН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03-р сарын 28 өдөр

Дугаар 02

Хархорин сум

2014 оны санхүүгийн тайлантай  
холбогдуулан ТУЗ-ийн гаргасан  
дүгнэлтийн тухай

“Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн  
ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.9  
дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

Компанийн 2014 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай ТУЗ-ийн гаргасан  
дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

# “ХАРХОРИН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03-р сарын 28 өдөр

Дугаар 03

Хархорин сум

2014 оны ногдол ашигтай холбогдуулан  
ТҮЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах тухай

“Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/2015 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46.6 дахь заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

2014 оны жилийн санхүүгийн тайлангийн дагуу 110,057.08 мянган төгрөгийн алдагдалтай ажилласантай холбогдуулан 2014 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.БИШРЭЛ

# “ХАРХОРИН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03-р сарын 28 өдөр

Дугаар 04

Хархорин сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон  
хараат бус гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалтыг удирдлага болгон “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр

- ✓ Б.Бүрэн
- ✓ С.Амгалан
- ✓ Д.Баярмаа нарыг баталсугай.

Хоёр. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр

- ✓ П.Учрал
- ✓ П.Бишрэл
- ✓ О.Төмөрбаатар
- ✓ Л.Хосбаяр
- ✓ Ж.Энхтөр
- ✓ Ц.Энх-Амгалан нарыг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

П.БИШРЭЛ



# “ХАРХОРИН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03-р сарын 28 өдөр

Дугаар 05

Хархорин сум

Компанийн 2015 оны үйл ажиллагааны  
төлөвлөгөө батлах тухай

“Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн  
ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигдийн ээлжит  
хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг шинээр сонгогдсон Төлөөлөн  
Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

П.БИШРЭЛ



# “ХАРХОРИН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 03-р сарын 28 өдөр

Дугаар 06

Хархорин сум

Их хэмжээний хэлцэл хийх тухай

“Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.15-ийг удирдлага болгон Хувьцаа эзэмшигдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн хүрээнд “Хархорин” ХК-ийн 200 га талбайд чацарганы аж ахуй байгуулах төслийг санхүүжүүлэх зориулалтаар банк, санхүүгийн байгууллагаас нийт 4,039,900,000 (дөрвөн тэрбум гучин есөн сая есөн зуун мянган) төгрөгийн хөнгөлөлттэй зээл авах, тус зээлийн барьцаанд компанийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших эрх болон үйл ажиллагааны орлогыг барьцаалахтай холбоотойгоор их хэмжээний хэлцэл байгуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

П.БИШРЭЛ

